



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 8/63

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажил зохион байгуулахтай холбогдуулан сумын төвийн хоосон хашаануудын эздийг олж тогтоон бүртгэл хяналтыг сайжруулах, хог хаягдлыг цэвэрлүүлэх, хашаа хороог цэгцлүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Янжиндулам (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: И.Маралмаа (Газрын даамал)

С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)

Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)

Г.Сугар (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын мэргэжилтэн)

Ж.Батмөнх (Байгаль хамгаалагч)


Б.Энхмаа (Байгаль хамгаалагч)

Ц.Цэнд-Аюуш (Цаг уурч)

Ж.Энхзаяа (Соёлын төвийн Орон нутаг судлах танхимын ажилтан)

2. Дээрх ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 25-ны дотор үр дүнтэй зохион байгуулж, танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Янжиндулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН